



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2024/01/НА-СА-ТЕЗ

Цахим хуудас: uvs@audit.mn Улаангом хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn
	Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Намжил Утас: 70453721 Цахим хаяг: Namjilt@audit.gov.mn
	Аудитор: Т.Амармэнд Утас: 70453721 Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn
	Аудитор: Б.Нямбуу Утас: 70453721 Цахим хаяг: Nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨСВИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ч.ЧИМЭД ТАНАА

2024.04.19. № УВА-2024/01/НА-СА-ТЭЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 493.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн, өмнөх оны аудитаар тогтоосон 39.1 сая төгрөгийн төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно", 4.1.36 дахь заалтад "Төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.3 дахь заалтад "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10 дахь заалтад "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын

0200200978

үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 14.4 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэгт “Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ”, 40.4 дэх хэсэгт “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна”, 40.4.1 дэх заалтад “Төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллах” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байх бөгөөд “Толилуулга”, “Нийцсэн ба зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөр, хүнсний нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардлаас 2023 онд ХААН банкны Увс салбартай гэрээ байгуулан 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг банкнаас олгох зээлийн хүүгийн төлбөрийн зарим хэсгийг төлөхөд гэж олгосон байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
ҮДТ	Үр дүнгийн тайлан
МГТ	Мөнгөн гүйлгээний тайлан
ӨӨТ	Өмчийн өөрчлөлтийн тайлан
ТГТ	Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		34,748,408.9	57,619,998.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	9,715,937.1	14,641,828.2
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	7,118,988.5	8,362,210.9
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	600.0	40,253.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	17,565,062.6	34,292,699.3
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	347,820.7	283,006.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		91,145,571.6	114,266,035.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	91,145,571.6	114,266,035.4
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		81,738,038.9	104,901,801.5
39300	Биет бус хөрөнгө	13	9,407,532.7	9,364,233.9
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		125,893,980.5	171,886,033.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,811,651.2	5,528,446.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	2,960,583.0	4,290,866.4
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	2,553,578.4	4,271,466.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	407,004.6	19,399.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		851,068.2	1,237,579.7
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	851,068.2	1,237,579.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		122,082,329.3	166,357,587.3
51	Засгийн газрын хувь оролцоо		122,082,329.3	166,357,587.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		15,437,287.6	15,437,407.6
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		29,953,506.8	30,217,675.6
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0

51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		1,691,316.6	1,691,316.6
51200	Хуримтлагдсан үр дүн		67,091,901.5	111,226,344.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		7,908,316.9	7,784,843.2
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	0.0
51600	Нөөцийн сан		0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо		0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		125,893,980.5	171,886,033.4

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		71,643,278.6	125,814,765.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		16,702,361.4	19,024,355.9
110	Орлогын албан татвар		12,412,881.5	14,249,416.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		12,905,693.9	14,461,888.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(703,429.4)	(912,475.7)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		210,617.0	700,003.4
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		1,770,504.9	2,236,405.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,518,975.0	2,538,533.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	45,166,406.4	87,068,737.2

120	Нийтлэг татварын бус орлого		22,983,876.3	55,289,288.1
121	Хөрөнгийн орлого		323,343.7	200,904.0
122	Тусламжийн орлого		0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		21,859,186.4	31,578,545.1
124	Зээлийн орлого		0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,774,510.9	19,721,672.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	45,802,218.4	54,692,200.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		45,802,218.4	54,692,200.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		44,138,858.9	48,857,078.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,101,349.8	13,946,928.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,489,445.3	1,717,347.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,269,610.5	1,734,539.4
2104	Хангамж, бараа материалын зардал		1,737,689.4	2,465,652.8
2105	Нормативт зардал		2,457,444.8	1,361,487.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		716,889.1	427,263.3
2107	Томилолт, зочны зардал		332,744.7	532,684.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,689,088.4	14,803,196.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13,344,597.0	11,867,978.3
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		28,000.0	26,700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,635,359.6	5,808,421.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		25,841,060.2	71,122,565.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		161,662,045.6	27,111,596.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(135,820,985.4)	44,010,969.2

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		62,420,130.6	84,379,658.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		17,074,876.0	18,650,492.4
110	Орлогын албан татвар		12,790,651.1	13,875,553.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		12,909,600.0	14461888.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(703,429.4)	(912,475.7)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		584,480.5	326,139.9
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		1,770,504.9	2,236,405.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		2,513,720.0	2,538,533.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		368,279.4	930,199.9
1181	Газрын төлбөр		1,316,419.2	717,861.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		829,021.5	890,472.3
1183	Бусад татвар		0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		35,574,403.9	46,083,867.2
120	Нийтлэг татварын бус орлого		13,391,873.8	14,304,418.1
121	Хөрөнгийн орлого		323,343.7	200,904.0
122	Тусламжийн орлого		0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		21,859,186.4	31,578,545.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		9,770,850.7	19,645,298.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		42,500,114.3	49,977,808.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		42,500,114.3	49,977,808.3

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		40,623,776.8	44,150,750.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,268,067.2	16,778,785.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,774,556.9	2,258,172.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		9,895,142.1	1,980,045.7
2104	Хангамж, бараа материалын зардал		2,111,781.0	3,585,649.2
2105	Нормативт зардал		2,537,123.5	1,471,627.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		755,939.7	475,640.7
2107	Томилолт, зочны зардал		324,802.1	506,181.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,037,143.8	11,793,496.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		7,919,220.5	5,301,151.2
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		28,000.0	26,700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,848,337.5	5,800,358.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		19,920,016.3	34,401,849.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		20,397,534.6	27,632,390.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		20,397,534.6	27,632,390.2
2200	Дотоод эх үүсвэрээр		20,397,534.6	27,632,390.2
2260	Гадаад эх үүсвэрээр		0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(20,397,534.6)	(27,632,390.2)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		(2,512,185.0)	(1,843,568.6)
14	Бусад эх үүсвэр		0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		2,417,075.0	1,701,418.6
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР		0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		95,110.0	442,150.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		(2,989,703.4)	(4,925,891.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		12,705,640.4	9,715,937.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,715,937.1	14,641,828.2

2.4. АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	260,733,543.6	0.0	260,733,543.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,786,057.3)	0.0	(3,786,057.3)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	256,947,486.2	0.0	256,947,486.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(22,961.0)	0.0	(22,961.0)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	598,932.0	0.0	598,932.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	379,857.5	0.0	379,857.5
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	(135,820,985.4)	0.0	(135,820,985.4)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,082,329.3	0.0	122,082,329.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,082,329.3	0.0	122,082,329.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	123,473.6	0.0	123,473.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,205,802.9	0.0	122,205,802.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(123,473.6)	0.0	(123,473.6)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	120.0	0.0	120.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	264,168.8	0.0	264,168.8
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	44,010,969.2	0.0	44,010,969.2
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	166,357,587.3	0.0	166,357,587.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь “Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж үр дүнг тооцох, иргэдэд төрийн бүх талын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, шударга ёсыг эрхэмлэн дээдлэх, төрийн захиргааны манлайллыг дээшлүүлэх эрхэм зорилгыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилгыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлэх;
- Төрийн хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;
- Хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах;
- Иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хөнгөн шуурхай хүргэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд - 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр,
- Төсвийн тухай хуульд - 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр,
- Хөдөлмөрийн тухай хуульд - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдөр, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр,
- Төрийн албаны тухай хуульд - 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус өөрчлөлт орсон.
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн сайдын

тушаалаар баталсан жишиг бичиг баримт, Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамаарах 8 сумын 56 төсөвт байгууллага, аймгийн төвийн 17 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж 339 зөрчил илрүүлж, 861.0 сая төгрөгийн 46 зөрчилд улсын байцаагчийн акт, 310 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна. 2023 онд шилэн дансанд хяналт шалгалт хийж, 146 байгууллага шилэн дансны сайтад 24790 мэдээллийг байршуулахаас 23332 мэдээллийг хугацаанд нь 880 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 292 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй, үлдэх 286 мэдээллийг байршуулаагүйд зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,992.1 сая төгрөгөөр буюу 36.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,715.9	14,641.8	4,925.9
Авлага	7,119.0	8,362.2	1,243.2
Урьдчилгаа	0.6	40.3	39.7
Бараа материал	17,565.0	34,292.7	16,727.7
Нөөцийн бараа	347.8	283.0	-64.8
Үндсэн хөрөнгө	91,145.6	114,266.0	23,120.4

Нийт хөрөнгө	125,893.9	171,886.0	45,992.1
Өр төлбөр	3,811.6	5,528.4	1,716.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	122,082.3	166,357.6	44,275.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	125,893.9	171,886.0	45,992.1

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансдуудыг доор харуулав. Үүнд:

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,715.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14,641.8 сая төгрөг болж, 4,925.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт(-)
Кассад байгаа бэлэн мөнгө	2.9	2.7	-0.2
Банканд байгаа бэлэн мөнгө	9,713.0	14,639.1	4,926.1
Дүн	9715.9	14,641.8	4,925.9
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	2,157.4	4,410.6	2,253.2
Төсөл/ сан	2,179.4	4,139.5	1,960.1
Төрийн сан	4,990.1	5,804.4	814.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	389.0	287.3	-101.7
Дүн	9,715.9	14,641.8	4,925.9

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Касс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нь “Чандмань-Увс” ХХК 2.6 сая төгрөг, Шинэ Улаангом ОНӨААТҮГ 0.1 сая төгрөг, нийт 2.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төрийн сангийн харилцах дансанд барьцаа хөрөнгийн 4,139.5 сая төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын 1,840.0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 1,615.2 сая төгрөг, техник хяналтын дансны үлдэгдэл 121.5 сая төгрөг, 19 сумын орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл 6,636.2 сая төгрөг, нийт 14,352.4 сая төгрөг байна. Арилжааны 4 банкны 36 харилцах дансанд 26 байгууллагын 286.7 сая төгрөг байршиж байна.

Арилжааны банкны мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар нь харуулбал: Үүнд:

- 18 сумын Эмийн эргэлтийн сангийн 20 дансанд 90.8 сая,
- “Чандмань-Увс” ХХК-ийн 6 дансанд 111.1 сая,
- “Улаангом тохижилт үйлчилгээ” УТҮГ-ын 4 дансанд 29.6 сая,
- “Тэс сумын Таван тэсийн илч” ОНӨААТҮГ-ын 1 дансанд 52.7 сая,
- “Шинэ-Улаангом” ОНӨААТҮГ-ын 5 дансанд 0.4 сая
- Өрхийн ЭМТөвүүдийн 4 дансанд 2.2 сая төгрөг тус тус байна.

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- **Өмнөговь сумын ИТХ:** Сумын ИТХ-ын даргын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/15 дугаар захирамжаар “Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд” аяны хоолны зардалд 1.3 сая төгрөгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гаргасан,

- **Сагил сумын ЗДТГ:** Засаг даргын нөөц хөрөнгөөс 2023 оны А/30 дугаар захирамжаар Улаанбаатар хотод “Алсын хараа-2050” хэлэлцүүлэгт оролцох, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад нутгийн зөвлөлийн гишүүдтэй уулзахад зориулан 2.0 сая төгрөгийн 50 ширхэг бэлгийн багц худалдан авсан, 2023 оны А/42 дугаар захирамжаар эх үрсийн баярын үйл ажиллагаанд зориулан 0.2 сая төгрөгөөр 7 ширхэг цүнх, 0.02 сая төгрөгөөр 7 ширхэг цэцэг худалдан авсан, 2023 оны А/63 дугаар захирамжаар Гаадан хамбын мэндэлсний 100 жилийн ойн бэсрэг наадмын морь, бөхийн шагналд 1.0 сая төгрөг зарцуулсан, 2023 оны Б/11 дүгээр захирамжаар Засаг даргын тамгын газрын даргад цэрэг татлагын ажлыг сайн зохион байгуулсан гэж 0.4 сая төгрөгийн урамшуулал олгосон, 2023 оны А/74 дүгээр захирамжаар Монгол улсын гавьяат эмч цол тэмдгээр шагнагдсан иргэнд 2.0 сая төгрөг олгосон,
- **Сагил сумын ИТХ:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 07 дугаар тушаалаар нягтлан бодогчийн ажил хавсран гүйцэтгэдэг Д.Мөнхтуулд 3, 4 дүгээр улирлын урамшуулал гэж 1.1 сая төгрөг олгосон,
- **Зүүнхангай сумын ИТХ:** Мөнгөн гүйлгээний журналаар 6.4 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн,
- **Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба:** Мөнгөн гүйлгээний журналаар 1.6 сая төгрөгийн орлогыг бараа материалын тайлангийн тодруулгад тусгаагүй шууд зардлаар тайлагнасан,
- **Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ:** Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 0.001 сая төгрөгөөр илүү тайлагнасан,
- **Чандмань Увс ХХК:** “Нээлттэй Увс аймаг” хөтөлбөрийг сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулахад аймгийн Засаг даргын Тамгын газарт 3.0 сая төгрөгийн хандив өгсөн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7,119.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,362.2 сая төгрөг болж 1,243.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3.9	11.0	+7.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	0.0	
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	
Зээлийн хүүгийн авлага	164.2	185.4	+21.2
Дансны авлага /ТӨҮГ/	130.2	218.9	+88.7
Бусад авлага	2,679.3	3,745.8	+1,066.5
Зээлийн авлага	4,141.4	4,201.1	+59.7
Дүн	7,119.0	8,362.2	+1,243.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,689.0	4,950.0	+261.0
Төсөл/ сан	1,648.5	1,879.8	+231.3
Төрийн сан	574.6	1,256.6	+682.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	206.9	275.8	+68.9
Дүн	7,119.0	8,362.2	+1,243.2

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт авлагын өсөлтөд ажиллагсадтай холбогдсон авлага 7.1 сая төгрөг, дансны авлага 88.7 сая төгрөг, бусад авлага 1066.5 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 21.2 сая төгрөг, зээлийн авлага 59.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлж байна.

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдлийн 4,307.3 сая төгрөг буюу 87 хувь нь Хоршоо хөгжүүлэх сангийн дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага, 642.7 сая төгрөг буюу 13 хувь нь төсөвт байгууллагын авлага эзэлж байна. Харин төсөл сангийн авлагын 1,787.0 сая төгрөг нь зураг төсвийн авлага, төрийн сангийн авлагын 1,256.6 сая төгрөг нь аймгийн орон нутгийн ерөнхий орлого дансны авлага, мөн 275.8 сая төгрөг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага эзэлж байна.

"Чандмань Увс" ХХК-ийн дансанд бүртгэлтэй Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийн үндсэн болон хүүгийн дамжуулан зээлийн төлбөрт төлсөн 1,177.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлснийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд авлагаар тусгасан байна.

Авлагын дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай 79.1 сая төгрөгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн авлага байна. Үүнд: аймгийн төсвөөс аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон үр тарианы болон бусад зориулалттай зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 53.0 сая төгрөгийн авлага байна. Мөн шүүхийн шийдвэр гарсан, барагдахгүй байгаа хоршооны 26.1 сая төгрөгийн авлага байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын илрүүлэлт:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зураг төсвийн авлага 2011-2023 оны хооронд үүссэн нийт 1,787.2 сая төгрөг байна. Үүнд авлагаар тусгагдсан инженер геологийн судалгаа, экспертизийн зардал, тухайн ажил нь хэрэгжихгүй удааширснаас шалтгаалан одоо ашиглах боломжгүй болсон зураг төсөв, тендер сонгон шалгаруулалт нь эрх шилжиж ирээгүй салбар яамнаас зарлахдаа зураг төсвийн үнийг тусгаагүйгээс барагдах боломжгүй болсон зэргээр данс бүртгэлээс хасах шаардлагатай найдваргүй авлага үүссэн байна.

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- **Сагил сумын ЗДТГ:** Шатах тослох материалын зардлаас 2.4 сая төгрөгийг илүү шилжүүлэн санхүүгийн тайланд материалын үлдэгдлээр тайлагнаж авлага тусгаагүй байсан,
- **Завхан сумын ЗДТГ:** Багаж, техник хэрэгслийн зардлаас 3.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж авахаар нэхэмжлэлийн дагуу төлбөр шилжүүлсэн ч хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй,
- Тээвэр шатахууны зардлаас 1.9 сая төгрөгийг хөндий орлого авч тайлагнасан,
- **Завхан сумын ИТХ:** Нягтлан бодогч нь 2023 оны 02 дугаар сарын цалин тооцохдоо нийгмийн даатгалын шимтгэл тооцоолох дүнгээс нийгмийн даатгалын тайлангаар 0.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан,
- **Тариалан сумын ЗДТГ:** Нэмэлт санхүүжилтийн данснаас Тариалан сумын Засаг даргын А/125 дугаар захирамжаар "Ундарга-Увс" ХХК-д гамшгийн үеийн бэлэн байдалд зориулж 4.3 сая төгрөг шилжүүлж бараа материалын үлдэгдэлээр тайлагнасан,
- **Бөхмөрөн сумын ЗДТГ:** Ажиллагсадтай холбогдсон авлагыг 0.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан,
- **Баруунтуруун сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлагыг 3.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан,
- **Малчин сумын ЗДТГ:** Ажиллагсадтай холбогдсон авлагыг 0.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан,

- **Түргэн сумын ЗДТГ:** “Зэст орой” ХХК-д бензин шатахууны үнэ 6.3 сая төгрөгийг урьдчилан шилжүүлэн орлого авсан боловч тухайн бензин шатахуун нь бодитоор байхгүй, авлага тусгаагүй,
- **Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн 2023 онд олгосон зээлийн хүүгийн авлагыг 7.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 0.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 40.2 сая төгрөг болж 39.6 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт № 4 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.6	40.1	+39.5
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа	0.0	0.1	+0.1
Томилолтын урьдчилгаа	0.0		
Дүн	0.6	40.2	+39.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага		0.1	+0.1
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.6	40.1	+39.5
Дүн	0.6	40.2	+39.6

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Тайлант оны эцэст урьдчилгаа дансанд “Чандмань-Увс” ХХК-ийн урьдчилж гарсан зардал 35.1 сая, Шинэ Улаангом ОНӨААТҮГ 5.0 сая, Улаангом сумын ЗДТГ 0.1 сая төгрөгийн үлдэгдэл байна.

3.4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 17,565.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 34,292.7 сая төгрөг болж, 16,727.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	765.9	797.3	+31.4
Хангамжийн материал	16,403.5	32,965.2	+16,561.7
Мал амьтад	395.6	530.2	+134.6
Дүн	17,565.0	34,292.7	+16,727.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	16,578.7	33,156.5	+16,577.8
Төсөл/ сан	0.0		0.0
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	986.3	1,136.2	+149.9
Дүн	17,565.0	34,292.7	+16,727.7

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Бараа материал 16,727.7 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Нийт нэмэгдсэн бараа материал 20,912.2 сая төгрөг:

- ⬇ Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,416.6 сая
- ⬇ Хандиваар авсан 16,992.5 сая
- ⬇ Бусад эх үүсвэрээр авсан 1,248.6 сая төгрөг

Нийт хасагдсан бараа материал 6,930.0 сая төгрөг:

- ⬇ Тайлант хугацаанд зарцуулсан 6,382.5 сая
- ⬇ Шилжүүлсэн 479.1 сая
- ⬇ Бусад 68.3 сая төгрөг

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 31,595.9 сая төгрөгийн хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4.5-д “... улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан барилга, байгууламжийг барьж дуусгах хүртэл захиалагч байгууллага нь бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэн санхүүгийн тайланд тусгана” гэж заасны дагуу төсвийн жил дамжин хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлыг захиалагч байгууллагын бараа материалын дансны эргэлтийн бусад хөрөнгөд бүртгэж тайлагнаснаас шалтгаалсан байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ:** Тайлант хугацаанд төлсөн 10.0 сая төгрөгийн даатгалын зардлыг бараа материал худалдан авах зардалд бүртгэсэн,
- **Завхан сумын ИТХ:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас худалдан авсан 0.5 сая төгрөгийн зургийн аппаратыг данс бүртгэлд тусгаагүй,
- **Өндөрхангай сумын ЗДТГ:** Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 80.9 сая төгрөгийн өвс тэжээлийг данс бүртгэлд тусгаагүй,
- **Бөхмөрөн сумын ЗДТГ:** Бараа материалын үлдэгдлийг 0.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Нөөцийн бараа материалын эхний үлдэгдэл 347.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 283.0 сая төгрөг болж, 64.8 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барааны нөөц	20.0	69.9	+49,9
Тэжээлийн нөөц	327.8	213.1	-114,7
Дүн	347.8	283,0	+64.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	20.0	69.9	+49,9
Төсөл/ сан	327.8	213.1	-114.7
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ			
Дүн	347.8	283,0	+64,8

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан өвс, тэжээлийн нөөц бүрдүүлж нөөцийн бараа хэсэгт бүртгэж, тайлагнасан байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 129,292.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 157,260.3 сая төгрөг болж, 27,967.9 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	50,257.6	59,155.9	+8,898.3
Авто тээврийн хэрэгсэл	7,720.6	8,392.4	+671.8
Машин тоног төхөөрөмж	14,478.1	15,510.5	+1,032.4
Тавилга, эд хогшил	2,627.1	2,781.5	+154.4
Зам, гүүрний байгууламж	33,691.1	43,516.8	+9,825.7
Түүх соёлын дурсгалт зүйлс	10.2	10.2	0
Бусад үндсэн хөрөнгө	10,528.7	17,849.8	+7,321.1
Дуусаагүй барилга, байгууламж	249.8	249.8	0
Ном	122.3	128.1	+5.8
Программ хангамж	123.8	134.1	+10.3
Бусад биет бус хөрөнгө	9,483.1	9,531.2	+48.1
Дүн	129,292.4	157,260.3	+27,967.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	103,978.2	131,889.6	+27,911.4
Төсөл/ сан	2.9	2.9	0.0
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	25,311.3	25,367.8	+56.5
Дүн	129,292.4	157,260.3	+27,967.9

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Тайлант онд үндсэн хөрөнгө данс нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,327.2 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 572.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 10,130.1 сая төгрөг, бусад эх үүсвэрээр авсан 18,432.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдсан 162.3 сая төгрөг, балансаас балансад шилжүүлсэн 1,042.1 сая төгрөг, акталсан хөрөнгө 1,305.4 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга, байгууламжийн үлдэгдэл 249.8 сая төгрөг байгаа нь Малчин, Наранбулаг, Өмнөговь, Улаангом сумдын Засаг даргын тамгын газрын дансанд бүртгэлтэй байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 119.5 сая төгрөгийн өртөгтэй Ковш тракторыг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/171 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн №1 дүгээр хүлээн авах акт үйлдэж Засаг даргын тамгын газрын данс бүртгэлд тусгасан байна. Сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/190 дүгээр санхүүжилт олгох захирамжаар 23-ны өдөр 100.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Гэтэл тухайн ковш нь хүлээж авах үед асахгүй байсан учир 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдөр гэхэд хүлээлгэн өгөх нэмэлт гэрээг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулж буцаасан байна. Тухайн хөрөнгө Өмнөговь суманд биетээр байхгүй байна.
- **Сагил сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдсэн 40.0 сая төгрөгийн Дүк машин, 29.0 сая төгрөгийн хүүхдийн тоглоомын талбай, 7.9 сая төгрөгийн Өндөрмод багийн төвийн тохижилт, засварын ажил, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр худалдан авсан 1.0 сая төгрөгийн принтер, нийт 77.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,

- **Сагил сумын ЗДТГ:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/09 дүгээр “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” тогтоолын хавсралтад тусгагдсан Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/ багц 2 “Сүү, цагаан идээ боловсруулах цехийн барилга”, 179.4 сая төгрөгийн ажлыг данс бүртгэлд тусгаагүй,
- **Өндөрхангай сумын ЗДТГ:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан 18.0 сая төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн,
- **Тариалан сумын ЗДТГ:** Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 16/09 дүгээр “Үндсэн хөрөнгө бүртгэх тухай” тогтоолын хавсралтад тусгагдсан 159.9 сая төгрөгийн жижиг оврын тэжээл боловсруулах цехийн тоног төхөөрөмж, Тариалан сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/58 дугаар захирамжаар жимс, жимсгэнийн зориулалтаар ашиглах 5 га 60.0 сая төгрөгийн газрыг данс бүртгэлд тус тус тусгаагүй,
- **Ховд сумын ЗДТГ:** Ховд сумын Засаг даргын тамгын газар нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас бэлтгэсэн 4.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрийг данс бүртгэлд тусгаагүй,
- **Бөхмөрөн сумын ИТХ:** Машин тоног төхөөрөмжийн үлдэгдлийг 0.9 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

3.4.7 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 3,811.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,528.4 сая төгрөг болж, 1,716.7 сая төгрөгөөр өссөн байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт(-)
Өглөг	2,553.6	4,271.5	+1,717.9
Урьдчилж орсон орлого	407.0	19.4	-387.6
Урт хугацаат зээл	851.1	1,237.6	+386.5
Нийт дүн	3,811.7	5,528.4	+1,716.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	153.0	131.9	-21.1
Төсөл, сан	1,519.6	3,729.3	+2,209.7
Төрийн сан	509.5	17.8	+491.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,629.6	1,649.4	+19.8
ДҮН	3,811.7	5,528.4	+1,716.7

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Өр төлбөрийн данс нь 1,716.7 сая төгрөгөөр өссөн нь барьцаа хөрөнгийн дансанд байршиж байсан хөрөнгө оруулалт болон бусад ажлын санхүүжилт 2,230.6 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,237.6 сая төгрөг болж 386.5 сая төгрөгөөр өссөн нь “Шинэ Улаангом” ОНӨААТҮГ-ын урт хугацаат өрийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын илрүүлэлт:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд барилгын барьцаа дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг 4,127.9 сая, өглөгийн үлдэгдэл 3,717.7 сая, зөрүү 410.2 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүнгээр бүртгэжээ. Энэ нь тухайн дансанд төвлөрүүлсэн зарим орлогыг өглөгөөр тусгаагүйтэй холбоотой байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ:** Богино хугацаат өр төлбөрийн дансанд хамаарахгүй байгаа 386.5 сая төгрөгийн дансны өрийг бусад урт хугацаат өр төлбөрийн дансанд шилжүүлэн бүртгэсэн,
- **Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан:** Баруунтуруун сумын Эмийн эргэлтийн сан нь эм ханган нийлүүлэх байгууллагуудад төлөх 17.5 сая төгрөгийн өр төлбөрийг дутуу тайлагнасан,
- **Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 5 ажлын 43.6 сая төгрөгийн дутуу санхүүжилтийг өглөгөөр тусгаагүй,
- **Бөхмөрөн сумын ИТХ:** Хувь хүний орлогын албан татварын өрийг 0.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан,
- **Бөхмөрөн сумын ЗДТГ:** Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн 1.7 сая төгрөгийн томилолтын өр төлбөр тусгасан,
- **Наранбулаг сумын ИТХ:** Хувь хүний орлогын албан татварын 0.2 сая төгрөгийн өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 122,082.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 166,357.6 сая төгрөг болж, 44,275.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 9 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт(-)
Засгийн газрын оруулсан капитал	15,437.3	15,437.4	0.0
Өмч /Төрийн/ ТӨҮГ	29,953.5	30,217.7	+264.2
Эздийн өмчийн бусад хэсэг ТӨҮГ	1,691.3	1,691.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	67,091.9	111,226.3	+44,134.4
Өмнөх үеийн үр дүн	202,912.9	67,215.4	-135,697.5
Тайлант үеийн үр дүн	-135,821.0	44,011.0	+179,832.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,908.3	7,784.8	-123.5
Дүн	122,082.3	166,357.6	+44,275.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	103,385.5	138,142.6	+34,757.1
Төсөл, сан, бусад	2,643.9	2,506.0	-137.9
Төрийн сан	2,514.4	7,043.2	+4,528.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	13,538.5	18,665.7	+51,272.0
Дүн	122,082.3	166,357.6	+44,275.3

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 166,357.6 сая төгрөг болж 44,275.3 сая төгрөгөөр өссөн байна.

Өмчийн дансны үлдэгдэл 30,217.7 сая төгрөг болж, 644.1 сая төгрөгөөр өссөн нь “Таван тэсийн илч” ОНӨААТҮГ болон “Чандмань Увс” ХХК-ийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 7,784.8 сая төгрөг болж 123.5 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээтэй хөрөнгийг бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Хуримтлагдсан үр дүн 111,226.3 сая төгрөг болж 44,134.4 сая төгрөгөөр өссөн байна.

3.4.9 Орлогын данс

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 125,814.8 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

Тайлант оны орлогыг өмнөх онтой харьцуулахад 54,058.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	16,669.8	19,024.3	+2,354.5
Татварын бус орлого	43,274.9	55,490.2	+12,215.3
Тусламж санхүүжилтийн орлого	11,811.9	31,578.5	+19,766.6
Нийт дүн	71,756.6	125,814.8	+54,058.2

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт орлогын дүн 125,814.8 сая төгрөг болж 54,058.2 сая төгрөгөөр өссөн байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Аймгийн ЗДТГ:** Нээлттэй Увс аймаг хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 29.0 сая төгрөгийн хандивыг аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан,
- **Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогыг 603.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

3.4.10 Зардлын данс

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт 54,692.2 сая төгрөгийн зардлыг тайлагнасан байна.

Хүснэгт № 11. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Бараа ажил үйлчилгээний зардал	44,025.5	48,857.1	+4,831.6
Урсгал шилжүүлэг	1,776.7	5,835.1	+4,058.4
Хөрөнгийн зардал	0.0	0.0	
Үйл ажиллагааны зардлын дүн	45,802.2	54,692.2	+8,890.0

/Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан/

Нийт зардлыг дүн 54,692.2 сая төгрөг болж 8,890.0 сая төгрөгөөр өссөн байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Аймгийн ЗДТГ:** Гадаад албан томилолтод зарцуулсан 2.6 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд дотоод албан томилолтын зардалд бүртгэсэн,
- Прокурорын газрын албан конторын барилга шинээр ашиглалтад орсонтой холбоотой тоног төхөөрөмж авахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.0 сая төгрөг зарцуулсан,
- Оросын Холбооны Улсын Тува улс аймгийн Засаг даргын хооронд хэлэлцээр гэрээ байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага судлах айлчлалын төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд 1206 л шатахууныг 2900 төгрөгөөр тооцон

3.5 сая, аймгийн Засаг даргын тамгын газар болон Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Алтай улсын хооронд албан ажлын уулзалт, харилцан хамтын ажиллагааны талаар санал солилцох хамтран ажиллах туршлага солилцох, төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд 900 л шатахууныг 2650 төгрөгөөр тооцон 2.4 сая, нийт 5.9 сая төгрөгийн шатахууныг Засаг даргын нөөц хөрөнгөөс худалдан авч тооцоо бодоогүй,

- Баруун бүсийн аймгуудын нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуультаан, ажилтнуудын сургалт, спортын арга хэмжээнд, ирсэн зочид төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэхэд засаг даргын нөөц хөрөнгөөс 3.3 сая, Алсын хараа-2050 хөтөлбөрийн хүрээнд Соёлын сэргэлт 2023 арга хэмжээг Увс аймагт зохион байгуулахаар ирсэн урлагийн алдартан, зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулахад Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.7 сая, Алсын хараа-2050, шинэ сэргэлтийн бодлогын үзэл баримтлал, “Нээлттэй Увс аймаг хөтөлбөр” хэрэгжүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн дэмжлэгээс Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар 8.2 сая, нийт 14.2 сая төгрөгийн бэлэг худалдан авсан,
- Аймгийн Төрийн архивын барилгын нээлтийн арга хэмжээнд зориулан хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахад 160 хүний хүлээн авалтад Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.7 сая төгрөг зарцуулсан,
- **Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ:** Тайлант онд “Их барилга” ХХК-д төлсөн 142,150.0 мянган төгрөгийн өр төлбөрийн дүнг үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардалд бүртгэснийг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зардлын хэсэгт ангилан бүртгүүлсэн,
- **Өмнөговь сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс тендерийн бичиг хэргийн материал худалдан авсан 0.1 сая төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй,
- **Завхан сумын ЗДТГ:** Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас дотоод албан томилолт, хэвлэл, хүлээн авалтын зэрэг зардлуудад 11.0 сая төгрөгийг зарцуулсан,
- **Завхан сумын ИТХ:** Сумын хурлын төлөөлөгчид болон мэргэжилтнүүдэд 0.5 сая төгрөгийн гар утасны нэгж авсан,
- **Завхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийг батлуулахдаа төсөл, хөтөлбөргүй 17.4 сая төгрөгийн 4 ажлыг батлуулж санхүүжүүлсэн,
- **Өндөрхангай сумын ИТХ:** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 2023 оны 02 дугаар сард 0.3 сая төгрөгийн урамшуулал авсан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар сарын цалин бодохдоо нягтлан бодогч нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаас үндэслэлгүйгээр 0.2 сая төгрөгийг суутган авсан,
- **Тариалан сумын ЗДТГ:** Засаг даргын тамгын газрын төсвөөс ажиллагсдыг аялалд явахад нь замын зардал гэж нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 2,100.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн,
- Тариалан сумын Засаг даргын Тамгын газрын санхүү албаны даргад Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг хариуцсан гэж хавсран ажилласны нэмэгдэл цалинд 2,369.3 мянган төгрөгийг олгосон,
- **Тариалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс Тарвагатай багийн иргэний сургалтын төлбөрт 4.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- **Улаангом сумын ЗДТГ:** Улаангом сумын Засаг даргын Тамгын газар нь хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Тува, Красноярскийн хязгаарын Курагино районд уулзалт, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын туршлага судлах, спортын наадам оролцох арга хэмжээний хүрээнд 5 удаагийн гадаад томилолтын зардалд

11.6 сая төгрөг гарсныг санхүүгийн үр дүнгийн тайлангийн дотоод томилолтын зардалд тайлагнасан,

- Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх уулзалт зөвлөгөөнд оролцсон Улаангом сумын 7 багийн Засаг даргад анхан шатны баримтын бүрдэл дутуу томилолтын хуудсаар нийт 4.9 сая төгрөгийн томилолтын зардал олгосон,
- **Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсвийг батлуулахдаа төсөл, хөтөлбөргүй 50.0 сая төгрөгийн 3 ажлыг батлуулж 49.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- **Зүүнговь сумын ЗДТГ:** Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр сумын Засаг дарга, ЗДТГ-ын даргад 0.8 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2023 оны А/14 дүгээр захирамжаар УИХ-ын гишүүнд 0.5 сая, А/56 дугаар захирамжаар Улаанбаатар хотод "Нээлттэй Увс" хөтөлбөрийн хүрээнд 0.4 сая, А/125 захирамжаар Соёлын төвийн 80 жилийн ойн хүрээнд хүрэлцэн ирсэн ахмадуудад 0.9 сая төгрөгийн бэлгийн багц, Засаг даргын захирамжаар алдарт уяачид 1.0 сая, А/130 захирамжаар алдарт уяачийн наадамд хүрэлцэн ирсэн нутгийн зөвлөлийн гишүүдэд 1.0 сая, А/123 дугаар захирамжаар сумын санхүүчдийн баярт 1.0 сая, нийт 4,9 сая төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулсан,
- **Зүүнхангай сумын ИТХ:** Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15/06 дугаар тогтоолоор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 20 төлөөлөгчид тус бүр 0.3 сая, нийт 6.0 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/13 дугаар захирамжаар нягтлан бодогчийн ажил хавсран гүйцэтгэдэг нягтлан бодогчид улирлын урамшуулал гэж 0.4 сая төгрөг олгосон,
- **Хяргас сумын ИТХ:** Санхүүгийн үр дүнгийн тайланд түлш шатах тослох материалын 1.2 сая төгрөгийн зардлыг тусгаагүй,
- **Улаангом тохижилт үйлчилгээ ОНТҮГ:** Санхүүгийн үр дүнгийн тайланд түлш шатах тослох материалын 17.4 сая төгрөгийн зардлыг тусгаагүй,
- **Хяргас сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс сумын Эрүүл мэндийн төвийн дотрын их эмчид 3.0 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- **Тэс сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүнг 578.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- **Ховд сумын ИТХ:** Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарын урамшууллыг 375000 төгрөгөөс тооцохоор байсныг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 550000 төгрөгөөс тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг 1.9 сая төгрөгөөр илүү төлсөн,
- **Ховд сумын ЗДТГ:** Ховд сумын Засаг даргын тамгын газар нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 17.0 сая төгрөгөөр Хяналтын явуулын пост бариулах гэрээгээр "Суман өргөө" ХХК-д урьдчилгаа санхүүжилт 11.9 сая төгрөг олгосон ч гэрээнд заасан хугацаанд тус ажил хийгдэж бүрэн дуусаагүй,
- **Бөхмөрөн сумын ЗДТГ:** 32.4 сая төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтын тооцоо бодоогүй, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зарцуулсан,
- **Баруунтуруун сумын ИТХ:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас “Үйлдлээрээ үлгэрлэгч Увсчууд” аяны хоолны зардалд 1.2 сая төгрөгийг гаргасан,
- **Малчин сумын ЗДТГ:** Үр дүнгийн тайланд цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,

- **Түргэн сумын ЗДТГ:** Улаанбаатар хотод Удирдлагын академийн орон нутгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах 2 өдрийн сургалтад оролцсон Засаг даргын тамгын газрын 27 албан хаагчдын унааны зардал 4.3 сая төгрөгийг тээвэр шатахууны зардлаас гаргаж зориулалт бусаар зарцуулсан,
- **Наранбулаг сумын ИТХ:** Үр дүнгийн тайлангийн зардлын дүнг 0.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан,
- **Наранбулаг сумын ЗДТГ:** Түр ажилласан ажилтны амралтын цалинг тооцохдоо 0.5 сая төгрөгийг илүү бодож олгосон, нийгмийн даатгалын шимтгэлийг 0.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан,
- **Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолоор Хурлын төлөөлөгчдийг чадавхжуулахад 5.8 сая, багийн засаг дарга нарын үйл ажиллагааг дэмжихэд 2.0 сая, нийт 7.8 сая төгрөгийн арга хэмжээг баталж зарцуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн 2023 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 14/01 дүгээр тогтоолоор 57823,7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 57,823.7 сая төгрөгийн төсөв баталснаас 11,324.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 42,489.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4,006.5 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 4.0 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 11,080.4 сая, орон нутгийн төсвөөс 40,024.9 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,732.3 сая, нийт 52,837.7 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч 2023 онд 23 хөтөлбөрийг санхүүжүүлэхэд 50,664.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 2,296.2 сая төгрөгөөр зээл олгохоор төсөвлөсөн ч Хоршоо хөгжүүлэх сангийн журмын шаардлагад нийцсэн хоршоо цөөн тул зээл олголт төлөвлөсөн хэмжээнээс 1,258.1 сая төгрөгөөр дутуу хэрэгжсэн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Орон нутгийн төсөвт байгууллагууд тодорхой хэмжээнд хэмнэлт гарган ажилласан, ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.

Хүснэгт 13. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөрийн нэр	Төсөв	Гүйцэтгэл	/сая төгрөг/
				Хэтрэлт, хэмнэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,544.9	3,318.2	226.7
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	36,252.1	31,604.4	4,647.7
3	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	288.4	286.4	2.0
4	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	270.4	264.4	6.0
5	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-
6	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	635.0	613.0	22.0
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	123.9	116.6	7.3
8	Мал аж ахуйг хөгжүүлэх	639.0	639.0	-
9	Авто зам	745.6	420.5	325.1
10	Ойжуулалт	269.4	241.1	28.4
11	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,283.3	1,281.6	1.7
12	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	555.9	451.0	104.9
13	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	799.8	739.3	60.5
14	Биеийн тамир спорт	348.9	348.9	0.0
15	Соёл урлаг	1,137.0	918.4	218.6
16	Сургуулийн өмнөх боловсрол	1,670.4	1,544.4	126.0
17	Ерөнхий боловсрол	5,606.1	5,507.6	98.6
18	Мэргэжлийн боловсрол	400.1	399.9	0.2
19	Нийгмийн халамж	831.8	807.7	24.1
20	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,296.2	1,038.1	1,258.1
21	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	34.6	34.6	-
22	Ахмад настны хөгжил хамгаалал	58.9	57.8	1.1
23	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	32.0	32.0	-
Нийт дүн		57,823.7	50,664.8	7,158.9

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.6.10 дахь заалтад “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь” гэж заасны дагуу 2023 онд Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 650.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр Сангийн яамнаас 700.0 сая төгрөгийг хуваарилж олгохоос 2022 онд урьдчилж олгосон 373.9 сая төгрөгийг суутган, 2023 онд зөрүү 326.1 сая төгрөгийн орлого хувиарлан олгосон байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд хандив, тусламж 65.7 сая, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-өөс 332.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 771.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,750.6 сая, нийт 5,920.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнээс: урсгал зардалд 5,371.5 сая, хөрөнгийн зардалд 548.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймагт тайлант онд дараах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/сая төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Төв цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамж /Польш улсын нөхцөлт зээл/	2023-2024	Цэвэрлэх байгууламжийн бусад барилга байгууламжийг барих нөхцөл бүрдэх.	Цэвэрлэх байгууламжийн гадна цахилгаан хангамжийн 4.8 км ЦДАШ, 2 ширхэг дэд өртөө барих ажил хэрэгжсэн байна.	423.0	104.4
2	Сургууль, цэцэрлэгийн дотуур байрны ариун цэврийн байгууламж /Эрдэнэт ТӨҮГ-ын хөрөнгө оруулалт/	2022-2024	Нүхэн жорлонгийн тоо, хөрс, агаарын бохирдлыг бууруулах.	Увс аймагт 1, 2-р ээлжийн Зүүнговь, Хяргас, Цгаанхайрхан, Завхан, Малчин, Сагил, Түргэн сумдын ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж ашиглалтад орсон байна.	3,698.2	3,698.2
3	Цэвэр усны ухаалаг тоолуур /НҮБ-ийн хүүхдийн хөгжлийн сан/	2023	200ш цэвэр усны ухаалаг тоолуур нийлүүлэх.	НҮБ-ийн Хүүхдийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламжаар 200 ш ухаалаг тоолуурыг Чандмань Увс ХХК-д нийлүүлсэн байна.	57.4	57.4

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил, аудитор Т.Амармэнд, Б.Нямбуу нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 7/569 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 546.9 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 54,692.2 сая төгрөгийн 1 хувь буюу 546.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 437.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хэрэгжүүлж ажиллаа.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн зүгээс харьяа Төсвийн төвлөрүүлэн захирагчдад 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/2200 дугаар “2023 оны батлагдсан төсөв хүргүүлэх тухай”, 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 1/1282 дугаар “2023 оны тодотгон батлагдсан төсөв хүргүүлэх тухай” албан бичгүүдээр

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах чиглэл өгч ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 21.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 10.6 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 11.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага, 18.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 144 мэдээллээс 113 мэдээллийг хугацаандаа оруулсан, 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Байршуулах хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт:

- **Өлгий сумын ЗДТГ:** Шилэн дансны цахим хуудаст 267.2 сая төгрөгийн 15 мэдээллийг байршуулаагүй, 165.9 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроосон,
- **Өлгий сумын ИТХ:** Шилэн дансны цахим хуудаст 27.3 сая төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроосон байршуулсан, 59.4 сая төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй,
- **Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч:** Шилэн дансны цахим хуудсанд 268.3 сая төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,
- **Ховд сумын ИТХ:** Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 88.0 сая төгрөгийн орлогын 12 гүйлгээ, 9.9 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 14 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй,
- **Ховд сумын ЗДТГ:** Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 569.9 сая төгрөгийн орлогын 40 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29.9 сая төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 57.0 сая төгрөгийн 18 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын сонгон шалгаруулалт явагдаж Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 130 дугаар "Нэр дэвшүүлэх тухай" тогтоол гарч тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан боловч хэрэгжүүлэн ажиллаагүй, аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан тушаалд 2020 оны 12 дугаар сараас, Хууль зүйн хэлтсийн даргын албан тушаалд 2021 оны 01 дүгээр сараас,

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд 2023 оны 04 дүгээр сараас, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан тушаалд 2023 оны 06 дугаар сараас, Худалдан авах ажиллагааны газрын даргын албан тушаалд 2024 оны 01 дүгээр сараас тус тус сонгон шалгаруулалт зарлахгүйгээр үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон албан хаагчид ажиллаж байна.

Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын ирүүлсэн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 07/768 дугаар албан бичгийн дагуу аймгийн ТЕЗ-ийн аудитын явцад хянан үзэхэд орон нутгийн төсвөөс жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд ямар нэгэн хөрөнгийн эх үүсвэр хуваарилаагүй, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5 дугаар заалтын хэрэгжүүлээгүй зөрчил байхгүй байна.

Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн талаарх мэдээллийг Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газарт Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 197 дугаар бичгээр хүргүүлсэн.

Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газраас ирүүлсэн 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 06/08 дугаар албан бичгийн дагуу хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон байж болзошгүй дараах 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 198 дугаар бичгийг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Үүнд:

1. Нээлттэй Увс аймаг хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 29,000.0 мянган төгрөгийн хандивыг аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авч зарцуулсан асуудалд холбогдуулан бусдаас хандив авч давуу байдал үүсгэсэн байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах тухай 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 130 дугаар албан бичгийг УАГ-т хүргүүлсэн. Хандив өгсөн Цэнгийн зам ХХК-ийг 2023 онд тендерт шалгаруулж ажил гүйцэтгүүлсэн нь нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд илэрлээ.

Аймгийн замын сангийн 417.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Хатуу хучилттай авто зам, тохижилтын /Улаангом 5-р баг/”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УВАОНӨГ/202312039 дугаартай тендерийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр болон 8 дугаар сарын 10-ны өдөр тус тус зарласан ба тухайн тендерт оролцогчид нь тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангахгүй байсан тул үнэлгээний хорооны зүгээс тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэний дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр захиалагчид хүргүүлсний дагуу аймгийн Засаг дарга 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр “Цэнгийн зам” ХХК-тай 416.8 сая төгрөгийн “Хатуу хучилттай авто зам, тохижилт /Улаангом 5-р баг/”-ын ажил гүйцэтгэх УВАОНӨГ/202312039 дугаар шууд гэрээг байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Ингэхдээ тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана”, 34.3 дахь заалтад “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаагүй байх бөгөөд тухайн тендерийг 2 удаа зарлахад оролцож тендерийн баримт бичигт тусгасан шаардлага хангахгүй гэсэн үндэслэлээр шалгараагүй “Цэнгийн зам” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар аймагт нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж аймгийн Засаг даргын ерөнхий дансны гамшгаас урьдчилан сэргийлэх тэмцэх зардлаас төсөвт тусгагдаагүй зээлийн хүүгийн төлбөрийн зарим хэсгийг төлөхөд дэмжлэг үзүүлж 39.1 сая төгрөгийг Хас банкны Увс салбарт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.5 дахь заалтад “төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх”, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэгт “Орон нутгийн төсөвт Өрийн удирдлагын тухай хууль болон энэ хуулийн 41.5, 57.4, 62.2-т зааснаас бусад тохиолдолд өр үүсгэх, баталгаа гаргахыг хориглоно”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, 39.1.3 дахь заалтад “хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, Өрийн удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хууль болон Төсвийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр өр үүсгэх, баталгаа гаргахыг хориглоно”, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Хас банкны Увс салбарын захиралтай байгуулсан “дотоод зах зээлд мах бэлтгэн нийлүүлэгчдэд зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах гэрээ”-ний 2.6.3-д “Зээлдэгч нь нөөцөлсөн үхрийн махыг 1 килограммыг 9000 /есөн мянга/ төгрөг буюу түүнээс доош үнээр, хонины махыг 1 килограммыг нь 8000 /найман мянга/ төгрөг буюу түүнээс доош үнээр борлуулах бөгөөд борлуулалтын үнийг тухай бүр олгосон НӨАТ-ын дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажуулна”, 4.3-д “Хамтын ажиллагааны тайланг талууд сар бүр, явцын мэдээг тухай бүр харилцан солилцож ажиллана” гэж заасантай нийцэхгүй байсанд төлбөрийн акт тогтоосон.

Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээд гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллагын дээд шатны захиргааны байгууллагад, эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана”, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэгт “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана” гэж заасны дагуу

гомдол гаргаагүй тул төлбөрийн акт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүчин төгөлдөр болсон.

Гэтэл 2023 онд аймгийн нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөр, хүнсний нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардлаас ХААН банкны Увс салбартай 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр **тендер, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр** 200.0 сая төгрөгийн гэрээ байгуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/47 дугаар захирамжаар 200.0 сая төгрөгийг банкнаас олгох зээлийн хүүгийн төлбөрийн зарим хэсгийг төлөхөд гэж олгосон байна.

Уг мөнгөнөөс ХААН банк олгогдоогүй байгаа зээлийн хүүгийн үлдэгдэл 166.6 сая төгрөгийг 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдөр гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөр, хүнсний нөөц бүрдүүлэх арга хэмжээний зардлын дансанд буцаан тушаасан байна.

Дахин ХААН банкны Увс салбартай 2023 оны 12 дүгээр сарын 15-ны өдөр тендер, худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 200.0 сая төгрөгийн гэрээ дахин байгуулан 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/798 дугаар захирамжаар 166.6 сая төгрөгийг банкнаас олгох зээлийн хүүгийн төлбөрийн зарим хэсгийг төлөхөд гэж шилжүүлсэн байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Төсвийн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 39.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 495.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдаагүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.
2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан мэдээллүүдийг хугацаанд нь шилэн дансны цахим сайтад байршуулж байх.

Хүснэгт: № 14. Зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	495.5	2	495.5	100
Албан шаардлага					
Төлбөрийн акт	1	39.1			
Нийт дүн					

Харин аймагт нөөцийн мах бэлтгэх, хадгалах, хавар худалдаалахад зориулж 39.1 сая төгрөгийг хүүгийн дэмжлэгт олгосон ба зээлийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, үр дүнг тооцож ажиллаагүйд тогтоосон төлбөрийн акт хэрэгжээгүй байна.

Төлбөрийн актыг хэрэгжүүлэн ажиллаагүй нь төлбөрийн актыг эс зөвшөөрч Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний аудитын газарт аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 1/916 дугаар бичгээр гомдол гаргасан боловч өнөөдрийг хүртэл хариу ирүүлээгүй байна гэсэн тайлбар өгсөн.

Төлбөрийн акттай холбоотой зөрчил тайлант онд давтагдан гарсан тул тайлангийн бусад хууль тогтоомжийн хэсэгт тусгаж хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар Үндэсний аудитын газарт албан бичиг хүргүүлсэн.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авлагын дансны үлдэгдэлд олон жилийн авлагууд байна. Тухайн авлагыг барагдуулах талаар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хандсан байх бөгөөд тухай авлага барагдсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд 2, нийцлийн аудитын хүрээнд 2, нийт 4 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

1. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зураг төсвийн авлага 2011-2023 оны хооронд үүссэн нийт 1,787.2 сая төгрөг байна. Үүнд авлагаар тусгагдсан инженер геологийн судалгаа, экспертизийн зардал, тухайн ажил нь хэрэгжихгүй удааширнаас шалтгаалан одоо ашиглах боломжгүй болсон зураг төсөв, тендер сонгон шалгаруулалт нь эрх шилжиж ирээгүй салбар яамнаас зарлахдаа зураг төсвийн үнийг тусгаагүйгээс барагдах боломжгүй болсон зэргээр данс бүртгэлээс хасах шаардлагатай найдваргүй авлага үүссэн байна.

Өгсөн зөвлөмж:

Зураг төсвийн авлагын үлдэгдэлд мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулан хуулийн хүрээнд дотоод хяналт хийж авлагыг бодит үлдэгдлээр нь илэрхийлэх.

Илрүүлэлт:

2. Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд барилгын барьцаа дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 4,127.9 сая төгрөгөөр, өглөгийн үлдэгдэл 3,717.7 сая төгрөгөөр, зөрүү 410.2 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүнгээр бүртгэжээ. Энэ нь тухайн дансанд төвлөрүүлсэн зарим орлогыг өглөгөөр тусгаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж:

Барилгын барьцаа дансны өглөгийн үлдэгдэлд мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулан хуулийн хүрээнд дотоод хяналт хийж өглөгийг бодит үлдэгдлээр нь илэрхийлэх.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Илрүүлэлт:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын сонгон шалгаруулалт явагдаж Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 130 дугаар "Нэр дэвшүүлэх тухай" тогтоол гарч тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргад даалгасан боловч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 130 дугаар "Нэр дэвшүүлэх тухай" тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах.

Илрүүлэлт:

2. Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан тушаалд 2020 оны 12 дугаар сараас, Хууль зүйн хэлтсийн даргын албан тушаалд 2021 оны 1 сараас, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан тушаалд 2023 оны 04 дүгээр сараас, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан тушаалд 2023 оны 06 дугаар сараас, Худалдан авах ажиллагааны газрын даргын албан тушаалд 2024 оны 01 дүгээр сараас тус тус сонгон шалгаруулалт зарлахгүйгээр үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон албан хаагчид ажиллаж байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" гэж заасны дагуу холбогдох газарт мэдээллээ хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Харьяа байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил:

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 186 төсвийн шууд захирагч, 19 төвлөрүүлэн захирагч, 23 төрийн

/орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан, нийт 230 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 152 тайланд дүгнэлт гаргаж, 78 тайланг түүвэрт хамруулсан.

Үүнээс 135 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 17 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн. Нэгтгэлд хамрагдсан 230 санхүүгийн тайлангаас 102 санхүүгийн тайлан тогтмол зардлын хувьд нэгтгэлд тусгагдсан байна.

Нэгтгэлд нийт санхүүжилтийн хувьд хамрагдсан 128 санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,804.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,311.1 сая төгрөгийн 29 алдааг залруулж, 12.0 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 27.9 сая төгрөгийн 5 зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, 453.6 сая төгрөгийн 27 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос 1,674.1 сая төгрөгөөр өссөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-											
Дүн	-											

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч	2	0					2	0				
Дүн	2	0					2	0				

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч	2	0					2	0
Дүн								
Нийт дүн	2	0					2	0

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
						Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Баруунтуруун сумын Засаг дарга	1	3.6			1	3.6	1	3.6				
Бөхмөрөн сум ЗДТГ	2	1.2	1	0.3	1	0.9	2	1.2				
Бөхмөрөн сумын ИТХ	2	1.8	1	0.9	1	0.9	2	1.8				
Завхан сум ИТХ	2	0.6	1	0.5	1	0.1	2	0.6				
Завхан сумын ЗДТГ	2	5.7	1	3.8	1	1.9	2	5.7				
Зүүнхангай сумын ИТХ	1	6.4			1	6.4	1	6.4				
Малчин сумын ЗДТГ	2	0.9	1	0.6	1	0.3	2	0.9				
Наранбулаг сумын Засаг дарга	1	7.7	1	7.7			1	7.7				
Наранбулаг сумын ИТХ	1	0.4	1	0.4			1	0.4				
Наранбулаг сумын ЗДТГ	1	0.8	1	0.8			1	0.8				
Өндөрхангай сумын ЗДТГ	2	98.9	1	80.9	1	18	2	98.9				
Сагил сумын ЗДТГ	1	179.4	1	179.4			1	179.4				
Тариалан сумын ЗДТГ	2	224.2	1	219.9	1	4.3	2	224.2				
Түргэн сумын ЗДТГ	1	6.3			1	6.3	1	6.3				
Тэс сумын Засаг дарга	1	1,182.6			1	1,182.6	1	1,182.6				
Хяргас сумын ИТХ	1	1.2	1	1.2			1	1.2				
Улаангом сумын ЗДТГ	1	11.6			1	11.6	1	11.6				
Улаангом сумын тохижилт үйлчилгээ ОНТҮГ	1	17.4	1	17.4			1	17.4				
Увс аймгийн ЗДТГ	1	2.6			1	2.6	1	2.6				
Увс аймгийн Санхүү хяналт, аудитын алба	1	1.6			1	1.6	1	1.6				
Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ	4	538.7			4	538.7	4	538.7				

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын Эмийн эргэлтийн сан	1	17.5	1	17.5			1	17.5				
Нийт дүн	32	2,311.1	14	531.3	18	1,779.8	32	2,311.1				

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт Зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баруунтуруун сумын ИТХ	1	1.2	1	1.2								
Бөхмөрөн сум ЗДТГ	1	34.1					1	34.1				
Завхан сумын Засаг дарга	1	17.4					1	17.4				
Завхан сум ИТХ	2	0.5					2	0.5				
Завхан сумын ЗДТГ	1	11.0			1	11.0						
Зүүнговь сумын Засаг дарга	1	3.0			1	3.0						
Зүүнговь сумын ЗДТГ	2	5.8					2	5.8				
Зүүнхангай сумын ИТХ	2	6.4	1	6.0			1	0.4				
Наранбулаг сумын Засаг дарга	1	7.8			1	7.8						
Өмнөговь сумын Засаг дарга	3	163.2					3	163.2				
Өмнөговь сум ИТХ	1	1.3	1	1.3								
Өндөрхангай сумын ИТХ	2	0.5	2	0.5								
Сагил сумын Засаг дарга	1	77.9					1	77.9				
Сагил сумын ИТХ	1	1.1					1	1.1				
Сагил сумын ЗДТГ	2	8.0					2	8.0				
Тариалан сумын Засаг дарга	1	4.0			1	4.0						
Тариалан сумын ЗДТГ	2	4.5			1	2.1	1	2.4				
Түргэн сумын ЗДТГ	1	4.3					1	4.3				
Ховд сумын ЗДТГ	2	16.0					2	16.0				
Ховд сумын ИТХ	1	1.9					1	1.9				
Хяргас сумын Засаг дарга	1	3.0					1	3.0				
Улаангом сумын Засаг дарга	1	49.7					1	49.7				
Улаангом сумын ЗДТГ	1	5.0					1	5.0				
Увс аймгийн ЗДТГ	5	62.8					5	62.8				
Увс аймгийн Чандмань-Увс ХХК	1	3.0	1	3.0								
Дүн	38	493.5	6	12.0	5	27.9	27	453.6				

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өлгий сумын Засаг дарга	1	268.3					1	268.3
Өлгий сумын ЗДТГ	1	433.2			1	433.2		
Өлгий сумын ИТХ	1	86.8			1	86.8		
Ховд сумын ЗДТГ	1	656.8			1	656.8		
Ховд сумын ИТХ	1	97.9					1	97.9
Дүн	5	1,543.1			3	1,176.9	2	366.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Аймгийн ЗДТГ	1	24.2					1	24.2
Наранбулаг сумын Засаг дарга	1	55.5					1	55.5
Тэс сумын Засаг дарга	2	268.9					2	268.9
Цагаанхайрхан сумын Засаг дарга	1	49.6					1	49.6
Цагаанхайрхан сумын Засаг даргын тамгын газар	1	24.8					1	24.8
Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	250.0					1	250.0
Дүн	7	673.0					7	673.0

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

/Т.НАМЖИЛ/

АУДИТОР

/Т.АМАРМЭНД/

/Б.НЯМБУУ/

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр